

Монгол Улс
НЭЗХДШ болон ТС-ийг боловсруулах хүрээнд эрдэмтэд, судалгааны байгууллагуудтай хийсэн
зөвлөлдөх уулзалт
2017 оны 8-р сарын 30

Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл ibaataarkhuu@worldbank.org и-мэйл хаягаар Б. Индратай холбогдоно уу.

Дэлхийн Банк Групп (ДБГ) нь Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодлоо солилцох зорилгоор 2017 оны 8 дугаар сарын 30-нд 10 эрдэмтэн судлаач нартай уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

- 1) Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
- 2) Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
- 3) Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Ангилал	Оролцогчдын санал
Улс орны хөгжлийн дүн шинжилгээ (ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга зам, боломж, сорилт, бэрхшээл)	<p>Сорилт бэрхшээл:</p> <ul style="list-style-type: none"> • Нийгэм-эдийн засгийн хөгжлийн сүүлийн үеийн бодлого богино хугацааны зорилго зорилтод хэтэрхий их чиглэсэн. • Баялгийн тэгш бус хуваарилалт болон хуулийн биелүүлэлт сул байна. • Засаглалтай холбоотой асуудлуудыг нэн түрүүнд шийдвэрлэх шаардлагатай. • Төрийн албаны чанарыг сайжруулж, хүнд суртлыг бууруулахын тулд нэн яаралтай төрийн албаны шинэчлэлийг хийх шаардлагатай. Танил тал, хамаатан саднаа төрийн албанд томилох явдал газар авсан. • Төр засгийн бодлого, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ хувийн хэвшил, нийгмийн хөгжилтэй эн зэрэгцэн хөгжиж чадахгүй байна. • Дата мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадвар сул, үнэн бодит мэдээлэл ховор болсон тул хөндлөнгийн үнэлгээний агентлагууд зэрэг дата мэдээллийг боловсруулдаг мэргэжлийн байгууллагуудыг хөгжүүлэх шаардлагатай байна. • Төрөөс үзүүлж буй боловсролын үйлчилгээний чанарт мөн анхаарах хэрэгтэй. Байгалийн баялаг ихтэй бусад оронтой харьцуулахад Монгол Улсын боловсролын салбарт оруулж буй хөрөнгө оруулалт бага байна. Маш их мөнгийг гадаадад боловсрол эзэмшихэд зарж байна. Хүмүүсийн сэтгэхүй, хандлагыг өөрчлөхөд анхаарах цаг болсон. Учир нь хүвь хүмүүсийн хариуцлага, ухамсар муудаж, халамжинд хэт их найдаж, төр засгийн гар хардаг болсон. Урт хугацааны тогтвортой ажил, орлоготой болох ажлын ёс зүй доройтон, хууль бус уул уурхайн үйл ажиллагаа явуулж богино хугацааны ажил хийж, халамжинд найдах болсон.

- Дээд боловсролд хэт их анхаарал тавьдаг боловч боловсролын салбарын цогц шинэтгэл хийх хэрэгтэй. Томоохон их дээд сургуулиудыг нийслэл хотоос гаргах шаардлагатай.
- Дундаж давхаргад ногдож буй татварын дарамтыг багасгах хэрэгтэй.
- Төсвийн алдагдал өндөр болон Засгийн газар хэт их зээл авч байгаагаас болж зээлийн хүү өндөр байна.
- Боловсролтой, туршлагатай Монгол хүмүүсийн чадвар, нөөц бололцоог улс орны хөгжилд сайн ашиглах шаардлагатай.
- Байгууллагын дотоод ой санамж богино, төрийн удирдлага тогтворгүй бөгөөд өөрчлөгдөн шинэчлэгдэх хүсэл эрмэлзэл бага байна.
- Намуудын санхүүжилтийн ил тод байдал дутмаг.

Боломж бололцоо болон хамтран ажиллаж болох салбарууд

Институц, засаглал болон иргэний нийгмийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг:

- Олон нийтэд үнэн бодит мэдээллийг хүргэж байхын тулд мэдээллийн үнэн зөв байдал, чанарыг хянадаг, үнэлдэг байгууллагуудыг бий болгох хэрэгтэй.
- Олон нийтийг мэдээллээр хангах, тэднийг оролцуулах зөвлөлдөхийг хөхиүлэн дэмжих хэрэгтэй.
- Бодлого боловсруулагч нар, хувийн хэвшил болон иргэдийн дунд мэдээлэл, мэдлэгийн хоосон орон зай байгааг багасгах.
- Төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо, ажил үүргийг нягтлан харах шаардлагатай.
- Төр засгийн ил тод байдал, мэдээлэл харилцааг сайжруулах
- Улс төрийн явцуу ашиг сонирхол, хувийн эрх ашгийн төлөө ажиллаж байгаа улс төрийн бүлгүүд улс орны хөгжилд тушаа болж байна.
- Засгийн газрын бодлогыг сайн, үр ашигтай хянахын тулд иргэний нийгмийн байгууллагуудыг бэхжүүлэх хэрэгтэй.

Төрийн албаны тогтвортой байдал болон шинэтгэл:

- Төр засаг, Засгийн газарт итгэх итгэл суларч байгаатай холбогдуулан институцуудыг бэхжүүлж, төрийн албыг сайжруулах хэрэгтэй.
- Төрийн албаны тогтвортой байдлыг сайжруулах, төрийн албыг улс төрийн сонгуулийн мөчлөгөөс хараат бус болгох.
- Төрийн албаны шинэтгэлийг явуулж, төрийн албаны томилгоог хянадаг хараат бус зөвлөл байгуулах.

Бодлого боловсруулалт, үнэлгээ болон хяналт мониторинг:

- Нотолгоонд суурилсан шийдвэр гаргах үйл явцыг хөгжүүлэн, судалгаа шинжилгээний байгууллагуудыг бэхжүүлэх.
- Нэгэнт батлагдсан бодлого болон бодлогын хэрэгжилт, үр дүнгийн талаар үнэлгээ, хяналт шинжилгээ хийх хэрэгтэй. Ингэснээр үр дүнтэй сайн бодлогуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, үр дүнгүй бодлогыг сайжруулахад түлхэц болно.
- Эрдэмтэн судлаачид, бодлого боловсруулдаг байгууллагууд хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай.
- Хариуцлагын тогтолцоог сайжруулах.

- Нийгмийн халамжаас хараат байдлаас ангижран, өөрийн амьдралд эзэн болох сэтгэлгээнд шилжвэл хүмүүсийн өөрсдийн нөөц бололцоог нээж өгнө. Төрийн халамж, дэмжлэг болон үүнийг даамжруулж байгаа улс төрийн алхамууд том асуудал болж байна.

Хөдөө аж ахуй, мал аж ахуй болон байгаль орчин:

- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг харгалзан хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх шаардлагатай.
- Олон нийтийн дунд уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах хэрэгтэй.
- Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийн чанарын баталгаа маш доогуур бөгөөд аюулгүй байдлын норм стандартууд байдаггүй буюу хэрэгждэггүй нь хүнсний аюулгүй байдал, иргэдийн эрүүл мэндэд ноцтой эрсдэл дагуулж байна. Антибиотик, эмийн бүтээгдэхүүн, пестицидуудыг хяналтгүй хэрэглэдгээс болж Монголд ургуулсан хүнсний ногоо, малын маханд итгэх олон нийтийн итгэл доогуур байна.
- Хөдөө аж ахуйн салбарын хөгжүүлэхэд сайжруулсан, шинэ технологи, бодлогыг авч хэрэгжүүлэх, импортын татвар, шимтгэлийг сайжруулан, гадаад зах зээлд холбогдох хэрэгтэй.
- Экспортын зах зээлийг өргөжүүлэх, Монголын махан бүтээгдэхүүний органик, бэлчээрийн зэрэг чанар, давуу талыг сурталчлах замаар махны экспортыг сайжруулах, арьс шир боловсруулах болон бусад ХАА-н үйлдвэрлэл, бүтээгдэхүүнд нэмүү өртөг илүү шингээх.
- Салбарын хөгжил болон Монгол хүмүүсийн эрүүл мэндэд малын эрүүл мэндийн асуудал маш чухал байр суурь эзэлж байна. Мэдээллийн нэгдсэн сан болон малыг хянах тогтолцоог хөгжүүлэх хэрэгтэй.
- Бэлчээрийн талхлал нэмэгдэж, татварын тогтолцоонд шударга бус хуваарилалт байгаатай холбогдуулан малын хөлийн татварыг ногдуулах. Өнөөдөр малчид маш олон өөр хэмжээний мал сүрэгтэй бөгөөд бэлчээрийг буруу хэрэглэсэнтэй холбоотой ямар нэг арга хэмжээ, хариуцлага тооцдоггүй. Бэлчээр хэрэглэсний татварын орлогыг эргээд малчдыг дэмжих, орон нутагт дэд бүтцийг хөгжүүлэхэд зарцуулах боломжтой.
- Байгаль орчны үнэлгээ, салбарын засаглал зэрэг асуудлуудыг оруулах ХАА болон уул уурхайн салбарын цогц үнэлгээг хийх шаардлагатай.
- ХАА-н салбарын тогтвортой хөгжүүлэхийн тулд гамшгийн эрсдэлийн удирдлагын хүрээг бэхжүүлэх хэрэгтэй. Үүнд дэвшилтэт технологийг ашиглах.

Боловсрол, хүний нөөцийг хөгжүүлэх:

- Боловсролын чанарыг сайжруулахад төвлөрөх.
- Иргэдийн иргэний боловсрол тааруу, мэдээлэл дутмаг байдаг тул иргэний боловсрол болон санхүүгийн боловсролыг сайжруулах хэрэгцээ нэмэгдсээр байна.
- Улс орны эрдэмтэн судлаач нарыг бүрэн дүүрэн ашиглах, гадаадад байгаа Монгол Улсын тэргүүлэх салбаруудад ажиллах судлаач нарыг эргүүлэн авчрах төсөл хэрэгжүүлэх хэрэгтэй.
- Сэтгэлгээний доройтол нэмэгдэж байгаатай холбогдон сэтгэлгээг өөрчлөх, ухуулан сурталчлах тодорхой ажлуудыг хийх хэрэгтэй.

- Дээд боловсролын чанар муу, маш олон тооны жижиг хувийн их дээд суруулиуд байгаатай холбогдон дээд боловсролын тогтолцоог цогцоор нь шинэчлэх, чанар, аттестатчлалын асуудлыг эргэн хянах.
- Дээд боловсролыг шинэчлэх улс төрийн сонирхол, хүсэл байхгүй байгаа нь нэг талаараа энэ салбарыг хөгжихгүй байгаагийн шалтгаан болж байна.
- Мэргэжилтнүүд тэтгэвэртээ гарч байгаатай холбогдуулах цаг тухайд нь мэдлэг чадвартай мэргэжилтнүүдээр солих хэрэгцээ шаардлага байна.
- Хөдөө орон нутагт ажилгүйдэл өндөр байгаагаас болж хот руу шилжих хөдөлгөөн их байна. Хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн, хотын хөгжилд тулгамдсан асуудлууд зарим талаараа их дээд сургуулиуд хотод төвлөрснөөс үүдэлтэй.

Бизнес, хөрөнгө оруулалт:

- Хөрөнгө оруулалтын үр ашиг болон арчилгааны зардал, чадавхийг үнэлэх шаардлагатай. Жишээ нь, жил бүр маш олон зам барьдаг ч арчилгаа муу байдаг тул замын засвар арчилгаа нь шинэ зам барихаас илүү тулгамдсан асуудал юм.
- Мега аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хэсэг хугацаанд тодорхой хязгаар тавих замаар дундаж давхаргыг дэмжих, бизнесийн өрсөлдөх чадварыг сайжруулах, жишээ нь тэдгээр аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг тодорхой салбар, үйлдвэрлэл, зах зээлээр хязгаарлах.
- Бизнесийн хөгжлийг дэмжихийн тулд зээлийн хүүг бууруулах арга хэмжээг судлах.
- Далайд гарцгүй улс орны хувьд худалдаа, бизнесийг дэмжихийн тулд дамжин өнгөрөх транзит корридоорыг хөгжүүлэх.
- Аж ахуйн нэгж, компаниудын судалгаа шинжилгээ хийх чадварыг дэмжих.
- Аж ахуйн нэгжүүдийг өөрсдийн үйл ажиллагааг сайжруулах, өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, жишээ нь ДБ-ны дэмжлэгтэй хэрэгжиж буй экспортыг дэмжих төсөл зэргээр дамжуулан.
- Уул уурхайн салбар дахь төрийн оролцоог хязгаарлан, өрсөлдөөнийг хөхиүлэн дэмжихийн тулд томоохон бизнесүүдийн хяналтыг сайжруулах.
- Дэд бүтэц, логистик, аж үйлдвэрийн салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах.
- БНХАУ-ын өрсөлдөх чадвар болон манай зах зээлийн хэмжээ жижиг гэдгийг харгалзан хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэхдээ болгоомжтой хандах.

Нийгэм, эдийн засгийн бодлого:

- Байгалийн баялгийн салбараас орж ирж буй орлогыг зөв зүйтэй сайн зарцуулах.
- Монгол Улс өнгөрсөн жилүүдэд зах зээлийн эдийн засаг, ардчилалд шилжихэд эдийн засгийн өсөлтийг бий болгох, шүүхийн шинэчлэл болон хүмүүсийн сэтгэлгээнд нэлээд их ололт амжилт гаргасан.
- Хөгжлийн бодлогыг сайжруулах хэрэгтэй, салбарын хөгжлийн бодлогуудыг шинэчлэн, салбарын бусад баримт бичигтэй уялдаатай болгох.
- Ядуурлыг хэмжих арга зүйг эргэн харах, жишээ нь олон талт ядуурлыг хэмжих аргыг ашиглах
- Орлогын тэгш бус байдлын үнэлгээг эргэн харах хэрэгтэй. Нийгмийн шударга ёсыг тогтоож, тэгш бус байдалтай тэмцэхийн тулд татварын хэмжээг нэмэгдүүлэхээс илүү татварын суурийг өргөн болгох тал дээр төвлөрөх хэрэгтэй.
- Хот суурин газрын тэлэлтийг сайн удирдан зохицуулахад онцгой анхаарах хэрэгтэй.

<p>ДБГ-ын стратеги болон хамтын ажиллагаанд өгсөн санал зөвлөмж</p>	<p>Цаашид дэмжих чиглэлүүд:</p> <ul style="list-style-type: none"> • Мэдээллийн чанарыг сайжруулж, олон нийтийн боловсрол, сэтгэлгээ иргэний боловсролыг сайжруулах • Иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан төр засгийн хариуцлагыг нэмэгдүүлэх • Бодлого төлөвлөлтийг илүү сайн зохицолгоо уялдаатай болгохын тулд төрийн удирдлагын тогтолцоо, салбар хоорондын уялдааг бэхжүүлэх • Бодлогын дүн шинжилгээ, нотолгоонд суурилсан бодлого боловсруулахыг дэмжих. Бодлогын судалгаа хийж байхад улс орны онцлогийг харгалзан үзэх шаардлагатай. • Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг бодлогын залгамж халаатай уялдуулах. • Хүний нөөц, капиталын өрсөлдөх чадварыг сайжруулах. • Нүүдлийн соёл, аж ахуйд суурилсан эко-аялал жуулчлалыг хөгжүүлэх урт хугацааны алсын харааг дэмжих • ХАА-н салбарт шинэ технолог, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэлийг бууруулах арга хэмжээ, шинэтгэл хийх • Уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулагч нар аль хэдийн үйл ажиллагаа явуулдаг тул энэ салбар дахь Дэлхийн Банкны оролцоо хязгаарлагдмал байх хэрэгтэй. • Өнгөрсөн 3 жилийн хугацаан дахь эдийн засгийн удааширсантай холбогдон үүссэн эдийн засгийн тодорхойгүй байдлаас улбаалж Дэлхийн Банк хувийн хэвшлийн шийдвэр гаргах, төлөвлөх үйл явцыг сайжруулах тал дээр дэмжлэг үзүүлэх хэрэгтэй, жишээ нь үйл ажиллагаа, төлөвлөлтийн зөв зохистой загваруудыг боловсруулахад тусалж, зөвлөмж өгөх. • Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлж, санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг чанарыг сайжруулах. • Уул уурхайн салбарт авлигатай тэмцэх стратеги боловсруулах. • Дэд бүтэц, гаалийн үйлчилгээ, татвартай холбоотой асуудлуудыг шийдвэрлэж, олон улсын хэм хэмжээг нэвтрүүлэх. • Мэдлэгийн салбар дахь инноваци, мэдлэгт суурилсан бизнесийг дэмжих. • Их дээд сургуулиудын судалгаа шинжилгээний чадавхийг бэхжүүлж, судалгаа, хөгжлийн салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах. • Хэвлэл мэдээллийн улс төрөөс хараат бус байдлыг дэмжих. <p>Арга зам болон хэрэгжилт:</p> <ul style="list-style-type: none"> • Төсөл, хөтөлбөрийн дизайныг сайжруулж, улс орны нөхцөл байдалд илүү тохиромжтой, нийцтэй болгох.
--	---

Уулзалтын үеэр оролцогчдоос авсан товч судалгааны хариу:

1. Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг бууруулж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	75.00%	6
–	62.50%	5
Төрийн удирдлага/шинэтгэл	62.50%	5
–	62.50%	5
Боловсрол	50.00%	4
–	50.00%	4
Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	50.00%	4
–	50.00%	4
Хүнсний аюулгүй байдал	50.00%	4
–	50.00%	4
Авлигатай тэмцэх	25.00%	2
–	25.00%	2
Хөдөөгийн хөгжил	25.00%	2
–	25.00%	2
Хотын хөгжил	12.50%	1
–	12.50%	1
Эрүүл мэнд	12.50%	1
–	12.50%	1
Эдийн засгийн өсөлт	12.50%	1
–	12.50%	1
Байгалийн нөөцийн удирдлага	12.50%	1
–	12.50%	1
Хувийн хэвшлийг хөгжүүлэх	12.50%	1
–	12.50%	1
Санхүүгийн зах зээл	12.50%	1
–	12.50%	1
Зам, тээвэр	12.50%	1
–	12.50%	1
Эрчим хүч	12.50%	1
–	12.50%	1
Ус, ариун цэврийн байгууламж	0.00%	0
–	0.00%	0
Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах	0.00%	0
–	0.00%	0
Худалдаа, экспорт	0.00%	0
–	0.00%	0
Эрх тэгш боломжоор хангах	0.00%	0
–	0.00%	0
Нийгмийн хамгаалал	0.00%	0

–	Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	0.00%	0
–	Гадаадын хөрөнгө оруулалт	0.00%	0
–	Гамшгийн эрсдэлийн удирдлага	0.00%	0

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж Та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

	Хүний хөгжлийг дэмжих	75.00%	6
–	Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	62.50%	5
–	Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	62.50%	5
–	Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	37.50%	3
–	Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих	37.50%	3
–	Бүгд чухал	0.00%	0